

2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр

ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХҮСЭЛТЭЙ ХУВЬ ХҮН/БАГ/, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД

Шинжээч сонгон шалгаруулах урилга хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газар нь “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудит”-д “Газрын тосны инженерийн зөвлөх үйлчилгээ” үзүүлэх шинжээч сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажиллах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын дагуу хэрэгжих бөгөөд сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Шинжээчийг сонгох урилга нь дараах бүрдэл хэсгүүдтэй. Үүнд:

- Ажлын даалгавар
- Саналын баримт бичиг

Шинжээч нь ҮАГ-АД/22-029 дугаар ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн байранд тус тус ажиллаж компанийн холбогдох үйл ажиллагаатай холбоотой баримт материалтай танилцана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд тайлан бичиж, дүгнэлт гарган холбогдох баримт бичгийг ажлын 22 хоногийн хугацаанд багтаан аудитын багт хүлээлгэн өгнө.

Сонирхсон этгээд нь Ажлын даалгавар, “Шинжээч сонгох саналын баримт бичиг” бусад холбогдох мэдээллийг www.audit.mn цахим хаягаас болон ҮАГ-ын Захиргаа, хууль, эрх зүйн газрын худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюушаас авч болно. Ажлын утас: 51-261745, гар утас: 88051068.

Саналыг файл хэлбэрээр info@audit.gov.mn, tsend-ayushn@audit.gov.mn цахим шуудангаар 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 17 цаг 00 минутаас өмнө ирүүлнэ үү.

Захиалагчийн хаяг: Үндэсний аудитын газар-15160. Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.

БАТЛАВ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Я.САРАНСҮХ



ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ӨРТӨГ НӨХӨХ ЗАРДЛЫГ
БАТАЛГААЖУУЛАХ АУДИТАД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХИЙН
АЖЛЫН ДААЛГАВАР

2022 оны 11 дугаар сарын
10-ны өдөр

Дугаар 441-АД/
22-029

Улаанбаатар
хот

Ажлын зорилго: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын ажилд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ өгөхөд оршино.

Ажил гүйцэтгэх хугацаа: 2022.11.21-2022.12.21

Байршил: Үндэсний аудитын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний аудитын газар (цаашид “захиалагч” гэх) Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Зөвлөх нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн байранд тус тус ажиллаж компанийн холбогдох үйл ажиллагаатай холбоотой баримт материалтай танилцана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд дэд тайлан бичнэ. Үүнд:

1. Гэрээлэгч 2019-2020 оны газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлтийг газрын тосны хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой боловсруулж, хянасан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
2. Гэрээлэгч 2019-2020 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тосны хайгуултай холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гаргах;

3. Гэрээлэгчийн 2019-2020 оны ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
4. Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөгдсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
5. Аудитын тайлангийн төсөл боловсруулах, тайлангийн төсөл хэлэлцүүлэхэд оролцох.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн талбайн 2019-2020 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээ, судалгаан дахь газрын тосны мэргэжлийн техникийн нэр томьёо, агуулга, орд ашиглалт, дэд бүтэцтэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Аудитын үе шат	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
Гүйцэтгэлийн үе шат	1. Гэрээлэгчийн газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлт нь газрын тосны хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	2. Гэрээлэгч жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тостой холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	3. Гэрээлэгчийн хайгуулын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Тайлангийн төсөлд он тус бүрээр дүгнэлт гарсан байна.
	4. Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.	Дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын талаар нотолгоонд суурилсан дүгнэлт гарсан байна.
	5. Хайгуулын үед авсан тоног төхөөрөмжийн худалдан авалтын төсөвт өртгийг баталгаажуулах санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх.	Гэрээлэгчийн 2019-2021 онд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг санхүүгийн зөвлөхийн ажлын тоо хэмжээтэй тулган баталгаажуулсан байх.
Тайлагналын үе шат	1. Аудитын тайлангийн төсөл боловсруулах, Аудитын зөвлөлийн хурлаар тайлангийн төсөл хэлэлцүүлэхэд оролцох.	Аудитын тайлан баталгаажсан байна.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд оролцох Зөвлөх /иргэн, хуулийн этгээд, баг байж болно/ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК-ийн 2019-2020 оны, Шунхлай энерги ХХК, Импейр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн 2015, 2016 оны хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэхэд Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан газрын тосны мэргэжлийн зөвлөх инженер нь ажил эхлүүлэхэд болон ажлын явцад хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлж, захиалагчтай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Үндэсний аудитын газар нь газрын тосны салбарт мэргэшсэн, зөвлөх үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвлөхтэй ажиллах бөгөөд тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхөд /багаар гүйцэтгэж болно/ дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;
Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Багийн ахлагч нь газрын тосны мэргэжлээр Зөвлөх инженерийн зэрэгтэй, гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үнэн бодит байдлыг хариуцаж, дүгнэлт гаргах эрх бүхий байх;
- Геологи, уул уурхай, ашигт малтмалын олон улсын чиг хандлага, газрын тосны технологийн болон үйл ажиллагааны мэдлэг мэдээлэлтэй, ажлын туршлагатай байх;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;
- Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

Ажиллах хүчний шаардлага:

- Газрын тосны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Газрын тосны зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх
- Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

Баг, хувь хүний хувьд:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;

- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Газрын тосны мэргэжлийн зөвлөх инженерийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАМГЫН ДАРГА

БАТЛАВ.

С.ЦЭРЭНБАЯР

Огноо: 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

9006109
9019120396

"ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР 2019-2020 ОНД ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХСӨН БОЛОН НӨХӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ АУДИТ" АУДИТАД "ГАЗРЫН ТОСНЫ ИНЖЕНЕРИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ" ҮЗҮҮЛЭХ ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

- МАЯГТ 1-САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ
- МАЯГТ 2-ОРОЛЦОХ ХҮСЭЛТ
- МАЯГТ 3-ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 4-САНАЛ БОЛГОЖ БҮЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ ХҮСНЭГТ
- МАЯГТ 5-АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
- МАЯГТ 6-БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ
- МАЯГТ 7-АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА
- МАЯГТ 8-ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 9-ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ
- МАЯГТ 10-ШИНЖЭЭЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

САНАЛЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (СӨХ)

№	Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: [Үндэсний аудитын газар 15160, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр.
2	Захиалагчийн оролцоо, үзүүлэх дэмжлэг, байр тоног төхөөрөмж: Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба Санхүү-нийцлийн аудитын газрын холбогдох багтай хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг авч ажиллана.
3	Шинжээчийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагатай эсэх: "тийм" эсвэл "үгүй" [үгүй]
4	Санал хүлээн авах хугацаанаас 2 хоногийн өмнө албан бичгээр ирсэн тодруулгад хариу өгнө. [Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль, эрх зүйн газар. Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш [send-ayushn@audit.gov.mn. Ажлын утас 51-26 17 45. Гар утас: 88051068]
5	Саналыг Монгол хэлээр ирүүлнэ.
6	Хураангуй жагсаалтад орсон шинжээч эсхүл хуулийн этгээд мөн жагсаалтад орсон бусад компанитай хамтран ажиллаж болно: /хамааралгүй/
7	- Шинжээчийн үйлчилгээг гүйцэтгэхэд ажлын 22 хоногийн мэргэжлийн үйлчилгээ шаардагдана. - Мэргэжлийн зөвлөх шинжээч нь: Зөвлөх нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй. Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн байранд тус тус ажиллаж компанийн холбогдох үйл ажиллагаатай холбоотой баримт материалтай танилцана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд дэд тайлан бичнэ. Үүнд: - Гэрээлэгч 2019-2020 оны газрын тосны орд ашиглалтын үеийн ажлын төлөвлөлтөйг газрын тосны хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой боловсруулж, хянасан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах; - Гэрээлэгч 2019-2020 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл, ашиглалтын талбайд гүйцэтгэсэн газрын тосны хайгуултай холбоотой үйл ажиллагааны өдөр тутмын мэдээг үнэн зөв, зохих журмын дагуу тайлагнасан эсэхэд дүгнэлт гаргах; - Гэрээлэгчийн 2019-2020 оны ашиглалтын үеийн жилийн тайлан мэдээ нь бодит гүйцэтгэлд тулгуурласан эсэхэд үндэслэлтэй, нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;

4.	Гэрээлэгчийн дэд бүтэц болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл нь хайгуулын үе шатны болон технологийн горимын дагуу бодитой төлөвлөгдсөн эсэхэд үндэслэлтэй нотолгоонд суурилсан дүгнэлт гаргах;
5.	Аудитын тайлангийн төсөл боловсруулах, тайлангийн төсөл хэлэлцүүлэхэд оролцох.
АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ	
Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй Монголын алт ХХК, Макс ойл ХХК, Капкорп Монголиа ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Шунхлай энерги ХХК, Импайр газ Монголиа ХХК, Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК-ийн талбайн 2019-2020 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээ, судалгаан дахь газрын тосны мэргэжлийн техникийн нэр томьёо, агуулга, орд ашиглалт, дэд бүтэцтэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.	
8	Гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг: Дээд хязгаар нь 5 280 000 /таван сая хоёр зуун наян мянган/ төгрөг байна. Үүнд ажлын хөлс болон томилолтын зардал, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн /хуулийн этгээд эсвэл баг/ бусад зардал багтах болно. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх, шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн дараах үндсэн мэдээллийг баталгаажуулан ирүүлнэ. Үүнд: - Оролцох хүсэлтийн маягтаар Албан хүсэлт буюу саналыг баталгаажуулж ирүүлэх. /Маягт 2/ - Оролцогчийн танилцуулга. /Маягт 3/ - Санал болгож буй мэргэжилтний намтар(CV). /Маягт 4/ - Ажил гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж. /Маягт 5/ - Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт. /Маягт 6/ - Ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга /Маягт 7/ Дараах нэмэлт мэдээллийг хавсарган ирүүлнэ. Хуулийн этгээд бол: - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /тусгай зөвшөөрөлтэй бол/; - Татварын өргүй тухай тодорхойлолт /цахимаас татан авсан/ ; - Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /цахимаас татан авсан/; - Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээллийг нотлох баримтаар ирүүлэх. Сүүлийн 3 жилээр /2019,2020,2021 он/; - Ажилтны анкет, боловсрол, мэргэжлийн гэрчилгээний хуулбар; - Санхүүгийн тайлан. Сүүлийн 2 жилээр /2020, 2021 оны жилийн эцсийн/. Хувь хүн/баг бол: - Иргэний үнэмлэхийн хуулбар; - Анкет /CV/; - Боловсрол, мэргэжлийн гэрчилгээний хуулбар; - Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний нотлох баримт ирүүлэх. /сүүлийн 3 жилээр 2019,2020,2021 он/;

	Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ. /нотариатжуулсан байх/ /Холбогдох тодорхойлолт, албан мэдэгдэл нь тухайн сонгон шалгаруулалтыг зарласан цаг хугацаанд хамааралтай байна/ Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага: <u>Баг, хувь хүний хувьд:</u> Үндэсний аудитын газар нь газрын тосны салбарт мэргэшсэн, зөвлөх үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвлөхтэй ажиллах бөгөөд тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна. Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхөд /багаар гүйцэтгэж болно/ дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана.Үүнд: Хуулийн этгээдийн хувьд: • Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг; Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: • Багийн ахлагч нь газрын тосны мэргэжлээр Зөвлөх инженерийн зэрэгтэй, гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үнэн бодит байдлыг хариуцаж, дүгнэлт гаргах эрх бүхий байх; • Геологи, уул уурхай, ашигт малтмалын олон улсын чиг хандлага, газрын тосны технологийн болон үйл ажиллагааны мэдлэг мэдээлэлтэй, ажлын туршлагатай байх; • Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй; • Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах; • Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай; • Хууль тогтоомжид заасан бусад шаардлага. Ажиллах хүчний шаардлага: • Газрын тосны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй; • Газрын тосны зөвлөх болон мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх • Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан; • Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй; • Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай; • Багаар ажиллах, ачаалал даах чадвартай байх; • Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно. Баг, хувь хүний хувьд: • Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар; • Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг; • Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
--	--

	• Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх); • Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.
10	Шинжээчийн үйлчилгээний хүрээнд хийгдэх тайланг Монгол хэлээр бэлтгэнэ.
	Ажлын даалгаварт заасан бусад нэмэлт шаардлага
11	Нууцлал: Шинжээч нь ажлын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.
12	Татвар [Холбогдох татвар, төлбөр хураамж нь санал болгосон үнэд багтсан байна];
13	Санал ирүүлэх тоо: эх хувь 1 /цахим PDF файлаар/ ирүүлнэ.
14	Санал ирүүлэх хаяг: Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Гар утас: 88051068. Мөн info@audit.gov.mn цахим шуудангаар давхар илгээх. Үндэсний аудитын газар.15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр. 3 дугаар давхар 305 тоот өрөө. Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. Ажлын утас: 51-261745.
15	Саналыг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 17 цаг 00 минутаас өмнө ирүүлсэн байна.

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [Шинжээчийн үйлчилгээний нэр]-г _____ төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна.

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

Холбоо барих утас: _____

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

(Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд/баг/хувь хүн дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. /Нотлох баримт ирүүлэх шаардлагатай/

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Үр чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, сролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

/Баталгаажуулалт/

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.